Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын
01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх [4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0.5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**4**	40
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.5	5
Хэсгийн оноо				**3**	**2.5**	25
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	3	30
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9.5**	**95**

БАТЛАВ: ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ..... Б.ДАШПҮРЭВ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ III, IV УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.08.12

№	Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах гишүүд
Нэг. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийн хүрээнд:			
1.1	Ёс зүйн дэд хорооноос албан хаагчдыг Соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллийн цагаар сургалт хийх, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг улирал бүр зохион байгуулах.	III, IV улирал	Бүх гишүүд
1.2	Яамны ажилтнууд болон шинээр томилогдсон албан хаагчдад зориулан цахим шуудан болон цахим хуудсаар дамжуулан төрийн албан хаагчийн ёс зүйн талаар мэдээлэл хүргүүлж танилцуулж байх.	Тухай бүр	Бүх гишүүд
1.3	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ёс зүйн талаар мэдлэг олгох цахим сургалтуудыг яамны хуудсаар дамжуулан байршуулах.	III, IV улирал	Бүх гишүүд
1.4	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд зориулсан сургалтад ёс зүйн зөвлөлийн гишүүдийг хамруулах, ёс зүйн чиглэлээр зохион байгуулагдсан бусад сургалтын мэдээллийг гишүүд хоорондоо хуваалцах, гишүүдийг чадавхжуулах.	Тухай бүр	Бүх гишүүд
1.5	Харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, гишүүдэд чадавхжуулах сургалт хийх.	IV улирал	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
1.6	"Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолыг харьяа бүх байгууллагуудад хүргүүлэх.	2025.09.01-ний дотор	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
1.7	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийж, холбогдох арга хэмжээг авах	2025.12.01-ний дотор	Бүх гишүүд
Хоёр. Иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, мөн хэвлэл мэдээллийн мөрөөр , өөрийн санаачилгаар, байгууллагын удирдлагын шийдвэрээр ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах чиг үүргийн хүрээнд:			
2.1	Удирдлагаас шилжүүлсэн албан хаагчдын Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авч бүртгэх, хуваарилах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга

2.2	“Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах, хуваарилах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
2.3	Хуваарилагдсан гомдол, санал, мэдээллийн дагуу хууль тогтоомжийн хүрээнд ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах.	Тогтоосон хугацаанд	Бүх гишүүд
2.4	Ёс зүйн зөрчлийг шалган тогтоосон дүгнэлтийг хорооны хурлаар хэлэлцэж, шийдвэрийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх.	Тогтоосон хугацаанд	Бүх гишүүд
Гурав. Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө, тайлан боловсруулах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах:			
3.1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн тайлан”-г гаргаж, Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, мэдээллээр хангах.	Тогтоосон хугацаанд	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
3.2	Ёс зүйн зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээлэл болон ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдол, хүсэлтийг судалсан тайлан, шийдвэр, хорооны хурлын тэмдэглэлийн иж бүрдлийг хангаж архивын нэгж үүсгэн, архивд хүлээлгэн өгөх.	Жилийн эцсээр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Төлөвлөгөөг хянасан:
Ёс зүйн дэд хорооны дарга

ТЗУГ-ын ХХ-ийн дарга Т.Ганбаатар

Төлөвлөгөөтэй танилцсан:

Гишүүд

ГТБГ-ын дарга Ч.Хишигдалай
АҮБГ-ын БТСХ-ийн дарга М.Мэндбаяр
ГТБГ-ын ахлах шинжээч Б.Бат-Оргил
СХГ-ын ахлах шинжээч А.Бямбадорж
ГБГ-ын ахлах шинжээч А.Дэлгэрсайхан

Төлөвлөгөөг боловсруулсан:
Нарийн бичгийн дарга

АҮБГ-ын БТСХ-ийн шинжээч Х.Шүрэнцэцэг

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 30-ний өдрийн 12/3/24 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/27 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагаагаа эхэлсэн. Ёс зүйн дэд хороо 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ёс зүйн дэд хорооны 2025 оны III, IV улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар 2025.08.12-ны өдөр батлуулсан. Ёс зүйн дэд хороонд 2025 оны байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, гомдол ирээгүй. Ёс зүйн дэд хороо албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийсэн. Эрсдэлийн I, II Түвшинд үнэлэгдсэн маш өндөр, өндөр эрсдэл бүхий албан тушаал эрхэлж байгаа 5 албан хаагчаар Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулсан.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ёс зүйн дэд хорооны 2025 оны III, IV улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан судалгаа, сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулах талаар яамны удирдлагуудад үүрэг өгч албан хаагчдын оролцоог бүрэн хангуулсан. Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооноос ирүүлсэн тогтоолуудыг Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанд тухай бүр хүргүүлсэн. Шинээр ажилд орсон ажилтнуудаас гаргасан байгууллагын соёлыг сайжруулахад анхаарах асуудлуудыг удирдлагын хуралд хэлэлцэж, шийдвэрлэх үүрэг өгч, хэрэгжсэн.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
1. Хамт олныг чадавхжуулах, албан хаагчийг хөгжүүлэх" сургалтын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны агентлагаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүй, Авлигын эсрэг хамтдаа сургалтад яамны ёс зүйн хорооны гишүүд хамрагдсан. 2. Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг гишүүдэд зөрчил хянан шийдвэрлэх талаар мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

3. Ёс зүйн хорооноос яамны нийт албан хаагчдын вайбер группээр дамжуулан 2025 оны 09 дүгээр сараас эхлэн долоо хоногийн нэгдэх өдөр бүр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр мэдээлэл хүргүүлж ажилласан.
4. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны нийт албан хаагчид, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албаны ёс зүйн дэд хорооны гишүүдэд Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооны гишүүн Анагаах ухааны доктор, дэд профессор, Хууль зүйн ухааны магистр С.Цэрэнбат "**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ БА ЭРҮҮЛ МЭНД**" сэдвээр 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр сургалт зохион байгуулсан. Тус сургалтаар "Ёс зүйн зөрчлийн нийтлэг шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйл, Ёс зүйн аюулгүй байдал, Стресс шархлаа" сэдвээр албан хаагчдад ойлголт, мэдээлэл өгсөн.
5. Монгол Улсын Ёс зүйн хорооноос "Судалгаа зохион байгуулах тухай" 2025.10.16-ны өдрийн 4/223 албан бичгээр ирүүлсэн судалгаанд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 64 албан хаагч, 54 иргэн судалгаанд хамрагдсан. Судалгааны талаар яамны ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд танилцуулсан. Судалгааны линк болон Qr кодыг албан хаагчдын группд оруулж, судалгаа бөглөх зааварчилгаа өгсөн. Судалгаанд албан хаагчдыг бүрэн хамруулахын тулд удирдлагуудын шуурхай хурал дээр Төрийн нарийн бичгийн дарга үүрэг өгсөн. Шатахууны нөөцийн хомсдолын үеэр яамны Газрын тосны бодлогын газар, Салбарын хяналтын газрын албан хаагчид, удирдлагууд шатахуун түгээх станциудаар ажиллаж байсан тул яамны 89 албан хаагчаас 64 оролцсон. Иргэдийн судалгаа: АҮЭАЯ-ны пейж хуудсаар дамжуулж, зар мэдээлэл, зааварчилгааг түгээж, 54 иргэн судалгаанд хамруулсан.
6. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд "ШИНЭ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ЁС ЗҮЙН СУРГАЛТ"-ыг 2025.10.31-ний өдөр сургалт зохион байгуулсан.
7. Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээнд яамны 70 албан хаагчийг хамруулж, албан хаагч бүрийн эрсдэлийн түвшинг тооцож, нэгтгэл дүн тайлан гаргаж Ёс зүйн хороонд 2025.11.20-ны өдөр хүргүүлсэн. Байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээнд яамны 70 албан хаагч хамрагдсан. Төрийн албан хаагч өөрийн чиг үүргийн хүрээнд ажиллахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох судалгаанд хамрагдсан албан хаагчдаас 43 нь бага эрсдэлийн түвшинд, 22 нь дунд эрсдэлийн түвшинд, 4 нь өндөр эрсдэлийн түвшинд, 1 нь маш өндөр эрсдэлийн түвшинд байна. Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээлийг тодорхойлох судалгаанд хамрагдсан албан хаагчдаас 40 нь бага эрсдэлийн түвшинд, 22 нь дунд эрсдэлийн түвшинд, 6 нь өндөр эрсдэлийн түвшинд, 2 нь маш өндөр эрсдэлийн түвшинд байна. Байгууллагын хэмжээнд Удирдах албан тушаалтны манлайллын хүрээнд "Хүний нөөцийн бодлого шударга бус" Эрсдэлийн түвшин "Маш өндөр" гэж үнэлэгдсэн байна. Мөн "Удирдлагын шийдвэр гаргалт шударга бус", "Дотоод зөрчил, маргааныг шийдэх тогтолцоо бэхжээгүй", "Байгууллагын үйл ажиллагаанд оролцоог хангадаггүй","Ялгаварлан гадуурхалтыг мэдээлдэггүй" зэрэг нь "Өндөр" эрсдэлийн түвшинд үнэлэгдсэн.
8. Эрсдэлийн I, II Түвшинд үнэлэгдсэн маш өндөр, өндөр эрсдэл бүхий албан тушаал эрхэлж байгаа 5 албан хаагчаар Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Шинэ ажилтнуудад зориулсан ёс зүйн сургалт анх удаа зохион байгуулж, байгууллагын соёлын элементүүдийн талаар болон ажлын анхны өдрийн сэтгэгдлээ хуваалцаж, цаашид байгууллагын соёлыг сайжруулахад анхаарах асуудлыг ярилцаж, удирдлагуудад Ёс зүйн дэд хороогоор дамжуулан санал хүргүүлсэн.	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилт байхгүй. Санхүү, зохион байгуулалтын дэмжлэг багатай.
Санал:	

1.Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх
2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааныудын санхүүжилт шийдвэрлэх
3. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг тогтмол чадавхижуулах

Шалгах хэсэг:

- ☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ТНБГ /Албан тушаал/ /Гарын үсэг/ Б.Дашпүрэв /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

ГЭЗГХАХ /Албан тушаал/ /Гарын үсэг/ Т.Ганбаатар /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Мэргэжилтэн /Албан тушаал/ /Гарын үсэг/ Шүрэнчимэг /Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 12 сарын 30